



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2025 оны 06 сарын 05 өдөр

Дугаар А/393

Булган сум

**Гадаадад албан томилолтын зардал гаргах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Сангийн сайдын “Гадаад албан томилолтын зардлын хэмжээ шинэчлэн батлах тухай” 2011 оны 188 дугаар тушаал, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны хуралдааны IV/25, IV/26 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг дарга Д.Пүрэв-Очир, Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Гадаад харилцааны мэргэжилтэн М.Энхжаргал нар 2025 оны 06 дугаар сарын 11-13-ны өдрүүдэд Бүгд Найрамдах Хятад Ард Улсад зохион байгуулагдах Зүүн Хойд Азийн Нутгийн Захиргааны Холбоо (NEAR)-ны 15 дугаар Бүгд хуралд оролцоход шаардагдах зардлыг хавсралтаар баталсугай.

2. Хавсралтад тусгагдсан 10,614,814 (арван сая зургаан зуун арван дөрвөн мянга найман зуун арван дөрөв) төгрөгийн 8,020,840 (найман сая хорин мянга найман зуун дөч) төгрөгийг Аймгийн Засаг даргын Тамгын газрын төсвөөс, 2,593,974 (хоёр сая таван зуун ерэн гурван мянга есэн зуун далан дөрөв) төгрөгийг Хүний нөөцийн хөтөлбөрөөс гаргахыг Аймгийн Засаг даргын Тамгын газар (Д.Наранбаяр)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР

6325010539

Аймгийн Засаг даргын 2025 оны  
...06 дугаар сарын 05...-ны өдрийн 4/393 дугаар  
захирамжийн хавсралт

Гадаад албан томилолтод шаардагдах зардлын тооцоо

Д/д	Зардлын нэр	Нэгжийн үнэ /төгрөг/	Дүн /төгрөг/
1	2	3	4
1	УБ-Бээжин-УБ чиглэлийн тийзний үнэ, 2 хүн	2,034,500	4,069,000
2	Бээжин-Шэньян-Бээжин чиглэлийн тийзний үнэ, 2 хүн	1,557,387	3,114,774
3	Томилолт, БНХАУ 2 хүн, 3 өдөр	571,840 /160\$*3,574 төг/	3,431,040
<b>Нийт дүн</b>			<b>10,614,814</b>